



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/97

Баянхутаг сум

**Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/471 тоот захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг холбогдох заавар, журмын дагуу 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 20 хоногт багтаан түргэн шуурхай чанартай хийж гүйцэтгэхийг "Сацманал" ХХК-ны малын эмч Н.Санжаадамба, "Унаган туур" БГБХН-ийн малын эмч Д.Цолмон, "Бумансувд гэрэл" ХХК-ны малын эмч Х.Сувд-Эрдэнэ, "Чандмань талын тан" ХХК-ны малын эмч Э.Бямбадорж, "Ханхар Их Арт" ХХК-ны малын эмч О.Эрдэнэбилэг нарт үүрэг болгосугай.

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хуваарийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тус бүрээр гарган нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд багийн хэмжээнд хамрагдвал зохих малыг бүрэн хамруулах, өрхийн судалгаа, маршрут гаргаж, малчдад урьдчилан мэдэгдэж малыг бэлэн байлгах, тарилгын хашаа хоолойг бэлтгүүлэх ажлыг багийн засаг дарга (Д.Буянбат, Д.Алтанчимэг, Г.Ганболд) нарт даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Б.Цэнд)-д даалгасугай.

5. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Б.Цэнд)-нарт даалгасугай .

6. Тарилгын явцын мэдээ мэдээллийг холбогдох байгууллагад танилцуулахыг мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Б.Тожилсүрэн)-д үүрэг даалгасугай .

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Мөнхнаран)-д даалгасугай.

ДАРГА



Б.АМГАЛАНБАТ

Б.Цэнд

Б.Амгаланбат

Хүснэгт 2
Боловсруулсан: Мал эмнэлгийн тасгийн мэдээлэлтэн
Хянасан: Засаг дарга

Баянхутаг сумын Засаг даргын
2024 оны 10 дугаар сарын
...01...-ны өдрийн 1/1 дугаар
Захирамжийн хавсралт

2024 ОНЫ БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ВАКЦИНЫ ХУВААРЬ

Д/д	Сум	МЭҮН	Хамруулах мал, амьтан /тоо, толгой/			Шаардлагатай вакцин		
			Хурга	Ишиг	Нийт	Тун	Хайрцаг	Шил
1	Баянхутаг	Сац манал	20124	8676	28800	28800	14	8
2		Унаган туур	9308	6492	15800	15800	7	18
3		Чандмань талын тан	4200	2000	6200	6200	3	2
4		Бумансув д гэрэл	7114	1886	9000	9000	4	10
5		Ханхар Их Арт	4327	1473	5800	5800	2	18
6	Нийт		45073	20527	65600	65600	32	16